



# Хүний нөөцийн гол ур чадварууд ЦУНБХТ

Техникийн зөвлөх: Чак Конлон  
2019 оны 11-р сарын 6-ны өдөр

---

# Сургалтын зорилт

Хүний нөөцийн чиг үүргүүд, түүний дотор гүйцэтгэлийн үнэлгээнд хүний нөөцийн гол ур чадваруудын гүйцэтгэх үүрэг

1. Ур чадварын (компетенц) тодорхойлолт
2. Гол ур чадваруудыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх шалтгаан
3. Хууль эрх зүйн хэрэгжилтийг хангах
4. Гол ур чадваруудын хэрэглээг таниулах
5. Гол ур чадваруудаас танилцуулах – Баг, хамтын ажиллагаа

---

# Ур чадварт суурилсан Хүний нөөц

- **Ур чадварууд нь** ажил үүргээ амжилттай хийж гүйцэтгэхэд шаардагдах бусдад **ажиглагдахуйц** ур чадвар, чадавх, мэдлэг, хувь хүний онцлог шинж чанар, мотивац, зан байдлын цогц бүрдэл юм
- **Гол ур чадварууд** нь хувь хүний түвшинд ажил үүргээ амжилттай хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх бол байгууллагын түвшинд байгууллагын зорилго, зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэнэ
- **Функцналь/техникийн ур чадварууд** нь нарийн/тусгай ажил мэргэжилд чиглэсэн ур чадварууд юм



# Хүний нөөцийн гол ур чадварууд яагаад чухал гэж?

- Ур чадварууд амжилтанд хөтлөх хүч юм.
- Мэдлэг, ур чадвар (техникийн ур чадварууд) нь амжилтанд хүрэх суурийг тавьдаг бол,
- Зан байдал (зан байдалд суурилсан гол ур чадварууд) нь таныг хэр зэрэг амжилтанд хүрэхийг шийддэг. Тухайлбал удирдан зохион байгуулах, асуудал шийдвэрлэх, багаар хамтарч ажиллах нь амжилтанд хүргэх зан төлөвүүдийн нэг юм.
- Гол ур чадварууд нь хүний нөөцийн дараах чиг үүргүүдийн хэрэгжилтийн хүрээнд бодитой, системтэй шийдвэр гаргах үндэс суурь болдог:
  - *Гүйцэтгэлийн үнэлгээ*
  - *Хүний нөөц бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт*
  - *Сургалт хөгжил*



Албан хаагчид эдгээр гол ур чадварууд болон тэдгээрт суурилж ажлын гүйцэтгэлээ хэрхэн үнэлүүлэх талаар ойлголттой байх

---


# Дасгал ажил

- Багаар ажиллах:

Ажил мэргэжлийн хувьд амжилттай ажиллаж буй хэн нэгний тухай эргэцүүлэн бодож, ямар мэдлэг, ур чадвар, зан байдал тухайн хүнийг амжилтанд хөтөлснийг ярилцах.

Ажилдаа хандах хандлага, зан байдлын хувьд яг ямар хүн болохыг ярилцах

Ямар зан байдал таныг амжилтанд хөтлөх вэ?



---

# Хууль эрх зүйн орчны өөрчлөлт шинэчлэл

- ТАТХ –ийн шинэчилсэн найруулга 2017.12.07
- ТАЗ-ийн 2-р тогтоолд, 2019.01.11
- *Удирдан зохион байгуулах*
- *Дүн шинжилгээ хийх*
- *Асуудал шийдвэрлэх*
- *Манлайлах*
- *Баг, хамтын ажиллагаа*

# Ур чадварт суурилсан ХН-ийн тогтолцоо



---

## Албан тушаалын тодорхойлолт

- Ур чадварууд нь албан тушаалын ангилал зэрэглэлийн дагуу албан тушаалын тодорхойлолтод орсон.
- Албан тушаалын тодорхойлолт нь хүний нөөц бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын суурь баримт бичиг болно.



---

# ХН бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт

- Хувь хүний мэргэжлийн түвшин, мэргэшсэн чиглэл нь хүний нөөц бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтанд томоохон үүрэг гүйцэтгэдэг бол:
- Ур чадвар, зан төлөв нь ажил үүргээ амжилттай хийж гүйцэтгэхэд туслана.
- Аливаа албан тушаалд ямар ур чадвар, зан байдалтай хүн таарч тохирохыг хүний нөөц бүрдүүлэлтийн мэргэжилтэн хамгийн сайн тодорхойлдог.
- Ур чадварт суурилсан сонгон шалгаруулалтыг зан төлөвт чиглэсэн ярилцлагын аргаар хийдэг.
- **Албан хаагчийг ирээдүйд ямар гүйцэтгэлтэй ажиллахыг тодорхойлох хамгийн шилдэг арга бол Өнгөрсөн үеийн гүйцэтгэл нь байдаг.**



---

# Гүйцэтгэлийн удирдлага

- Албан хаагч нь ажил үүргээ амжилттай гүйцэтгэхэд шаардагдах ур чадвар, зан байдлын талаар хангалттай ойлголт мэдлэгтэй байх.
- Удирдах албан тушаалтан албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлэхэд зохих дүрэм журмын дагуу үнэлгээг хийхээс гадна өөрийн зүгээс ур чадвар, зан төлөвийг үлгэрлэн харуулж байх.
- Гүйцэтгэлийн үнэлгээнд ур чадварын үнэлгээг оруулах.



---

# Сургалт, хөгжил

- Сургалт хөгжлийн арга хэмжээг гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулах. Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлох.
- Ажлын байран дахь сургалт, зорилтот ур чадвар эзэмшүүлэх сургалт эсвэл коучин (чиглүүлэх) арга хэмжээгээр Техникийн ур чадварыг эзэмших боломжтой.
- Ур чадварыг дараах арга хэмжээгээр хөгжүүлэх боломжтой:
  - Ажлын байран дахь сургалт
  - Ур чадвар эзэмшүүлэх үүрэг даалгавар
  - Менторинг (сургах), дагалдуулах
  - Сургалт, семинар



---

# Хүний нөөцийн төлөвлөлт

- Албан хаагчдын хөгжүүлэх шаардлагатай ур чадварыг тодорхойлохоос гадна шатлан дэвшихэд шаардагдах ур чадварыг эзэмших.
- Удирдлагын зүгээс шатлан дэвшихэд шаардлагатай ур чадварыг эзэмшсэн албан хаагчийг зөв оновчтой тодорхойлж нэр дэвшүүлэх.
- Шатлан дэвшихэд шаардагдах ур чадвар эзэмшүүлэх сургалтын хэрэгцээ шаардлагыг удирдлагын зүгээс тодорхойлох.



---

# ТАЗ-ийн 2-р тогтоолоор баталсан ур чадварууд

- Удирдан зохион байгуулах
- Дүн шинжилгээ хийх
- Асуудал шийдвэрлэх
- Манлайлах
- Баг, хамтын ажиллагаа

# Баг, хамтын ажиллагаа

Нэгдсэн зорилгод хүрэхийн тулд бусадтай нээлттэй, үр дүнтэй хамтарч ажиллах, харилцан итгэлцэл, хүндлэл, хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан чадварлаг баг бүрдүүлэх чадвар.

Түвшин 1 /Туслах/	Түвшин 2 /Гүйцэтгэх/	Түвшин 3 /Удирдах/
Хамтын ажиллагаандаа бусадтай нээлттэй, шударга харилцааг үүсгэж, итгэлцлийг бий болгодог.	Асуудлыг шийдвэрлэхэд бусад оролцогч талуудын оролцоог хангаж, багийн үйл ажиллагааг удирдан манлайлдаг.	Бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд гадаад, дотоод түнш, ажлын хэсэг, баг, хамт олонтой хамтран ажилладаг.
<ol style="list-style-type: none"><li>Бусдын үзэл бодлыг ойлгож, идэвхтэй сонсдог.</li><li>Өөрийн үзэл бодол болон мэдээллийг нээлттэй хуваалцдаг.</li><li>Чиг үүргээ биелүүлж, бусдаас суралцах хүсэл эрмэлзэлтэй байна.</li></ol>	<ol style="list-style-type: none"><li>Хүлээгдэж буй зорилго, үр дүнг оновчтой тодорхойлдог.</li><li>Шийдэлд хүрэхэд мэдээлэл цуглуулах, бусадтай туршлагаа хуваалцах зэргээр дэмжлэг үзүүлдэг.</li><li>Бусдын оролцоо, санал бодлыг хүлээн зөвшөөрдөг.</li></ol>	<ol style="list-style-type: none"><li>Албан хаагчдын гаргасан санал, багийн ажиллагаанд оруулсан хувь нэмрийг хүлээн зөвшөөрч урамшуулан хамтын ажиллагааны үр дүнтэй орчинг бүрдүүлдэг.</li><li>Багийн үйл ажиллагаанд ур чадвар бүхий хүмүүсийг сонгон оролцуулдаг.</li><li>Багийн гишүүдийн оролцоог жигд ханган, үр дүнг тооцдог.</li></ol>

---

# ЭНЭ БҮХЭН ТАНЫ АЖИЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?

## Дасгал ажил

Багаар маш үр дүнтэй ажилласан туршлагаасаа хуваалцана уу?

- Яг ямар мэдрэмж төрсөн бэ?
- Танай багийн гишүүдэд Баг, хамтын ажиллагааны ур чадварын 1-р түвшний аль зан төлөв давамгайл байсан бэ?
- Та ямар зүйлийг хийх боломжтой байсан бэ?

---

# Ур чадварыг үнэлэх

- Дасгал ажил: Баг, хамтын ажиллагааны ур чадвараа үнэлнэ үү.
- Та ажлын байран дээр ямар зан төлөвийг үзүүлэн харуулдаг вэ?
- Зан төлөв тус бүрийн тохирох үнэлгээ хийнэ үү.
  - Хамтын ажиллагаанд бусадтай нээлттэй, шударга харилцааг үүсгэж, бусдыг сайтар сонсдог
  - Бусдын үзэл бодлыг ойлгож, идэвхтэй сонсдог
  - Өөрийн үзэл бодол болон мэдээллийг нээлттэй хуваалцдаг
  - Чиг үүргээ биелүүлж, бусдаас суралцах хүсэл эрмэлзэлтэй
- Баг, хамтын ажиллагааны ур чадварын эцсийн үнэлгээ тань ямар байна вэ?
- Цаашид ямар ур чадварыг хөгжүүлэх шаардлагатай байна вэ? (Хамгийн бага оноо авсан ур чадвар тань юу байна вэ?)



---

# Дараагийн алхам

- Төвийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх шаардлагатай ур чадваруудыг тодорхойлох
- Ур чадваруудыг танилцуулах, эзэмшүүлэх
- Хүний нөөцийн чиг үүргүүдэд нэвтрүүлэх



**Баярлалаа!**

**Асуулт, хариулт**